

боломжтой, үр дүнгийн гэрээний биелэлтийн мөрөөр тодорхой ажил өрнүүлэх нь бага, олгож буй мөнгөн урамшууллыг нэмэгдүүлэх, урамшууллын олон төрлийг ашиглах шаардлагатай байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Гэхдээ дээрх олон төрлийн урамшууллын системийг шат дараатайгаар бий болгоход нилээдгүй цаг хугацаа шаардлагатай. Нэг л өдөр гэнэт бүгд шийдэгдэхгүй гэдэг нь ойлгомжтой. Тиймээс алба хаагчид хийх ёстой ажлаа л сайн хийсэн тохиолдолд цол, шагнал, урамшил, алдар хүнд, албан тушаал дэвших боломж нээлттэй юм байна гэсэн ухамсрыг төлөвшүүлэх явдал юм.

Өнөөдрийн хувьд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдыг албандаа хандах хандлага, хүсэл эрмэлзлэлийг өдөөж буй гол хүчин зүйл нь тэдгээрийн хэрэглэж буй цол юм. "Цол" бол алба хаагчдын эрхэмлэх зүйлийн нэг бөгөөд ажилтны ажлын бүтээмж, үр дүнд шууд нөлөөлдөг, урам зоригийг нэмэгдүүлж, баяр, баясал итгэл үнэмшил авчирдаг чухал хөшүүрэг нь байдаг.

САНАЛ: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, хүний нөөцийн хангалтыг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалтай уялдуулан нэмэх зайлшгүй шаардлагатай.

Түүнчлэн алба хаагчдын ажлын ачааллыг багасгах, тэнцвэржүүлэх, ажил дүгнэх үзүүлэлтийг оновчтой болгох талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх нь нэн чухал юм.

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ АЖИЛЛАГААНЫ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Э.АЛТАНГЭРЭЛ

ХСИС-ийн Хууль сахиулах удирдлагын академийн
8022 дугаар дамжааны суралцагч, цагдаагийн хошууч;

Б.Одбаатар

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийн
профессор, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа

Хураангуй: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч гэрч, хохирогчийг хамгаалах нь төрийн чухал чиг үүргийн нэг боловч үүнийг зөвхөн хуулийн байгууллагын хэрэгжүүлэх ажиллагаа гэж ойлгох нь өрөөсгөл юм. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгох гол ач холбогдол нь төрийн хамгаалал, хяналт, үйлчилгээний гадна үлддэг байсан гэрч, хохирогчийг хамгаалан. тэдэнд төрийн хамгаалалтын найдвартай байдлыг ойлгуулан таниулж, улмаар хэргийн үнэн зөвийг тогтоох үйл явцад өөртөө итгэл үнэмшилтэй оролцох боломжийг бүрдүүлж өгч байгаад түүний мөн чанар

оршдог. Үүний тулд холбогдох хуулийг олон нийтэд сурталчилан таниулах ажлыг хүртээмжтэй, оновчтой хэлбэрээр тасралтгүй зохион байгуулах. шүүх эрх мэдэл, хууль сахиулах болон төрийн, төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн тусламж дэмжлэгийг авах, хоорондын үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай гэдэг нь гадны өндөр хөгжилтэй улс, орны энэ төрлийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээ, төрийн бодлого. шийдвэр, тусгайлан боловсруулсан хөтөлбөр. түүний хэрэгжилт зэргээс тодорхой харагдаж байна.

Түлхүүр үг: Гэрч, хохирогч, гэмт хэрэг, төрийн бодлого, гэрч, хохирогчийг хамгаалах. олон улсын туршлага.

Олон улсын туршлага, анхаарах асуудлууд

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассемблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор "Тэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай" тунхаглалыг батлан гаргаснаар олон улсын хэмжээнд хохирогчийн эрхийн талаар гаргасан үндсэн баримт бичиг болсон байна ¹ . Энэхүү тунхаглалын 6 дугаар зүйлд "гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах"-ыг улсуудад уриалсан.

Ерөнхий Ассамблейн 2003 оны 58/4 дугаар тогтоолоор баталсан Авилгалын эсрэг конвенци, 2000 оны 55/25 дугаар тогтоолоор баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцид "Оролцогч улс бүр энэхүү конвенцид тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн зохих тохиолдолд тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс хамгаалах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн боломжийн хэмжээнд авна" гэж тус тус үүрэг хүлээлгэсэн байна.

Үүнд нийцүүлэн ихэнх өндөр хөгжилтэй орон гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалахад чиглэсэн хөтөлбөрийг олон жилийн турш хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд эндээс дүгнэхэд тэдгээр улс оронд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх мөрдөн шалгах ажиллагаанд гэрч, хохирогчийн хувийн аюулгүй байдал, түүнийг хамгаалах асуудал эрх зүйн тогтолцооных нь нэг чухал хэсэг болсон байна. Тухайлбал, АНУ, Англи, Герман, Австрали, Итали, Канад зэрэг орны гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх эрх

¹ *Хууль зүйн яам, Нээлттэй нийгэм форум.* "Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь" сэдэвт хэлэлцүүлгийн илтгэлийн эмхэтгэл. -УБ. 2016. 5 дахь тал.

зүйн бие даасан зохицуулалтыг бүрдүүлсэнээс гадна хөрөнгө, санхүү, зохион байгуулалтын арга хэмжээг цогц байдлаар тусгасан тусгай хөтөлбөр батлан хэрэгжүүлж энэ талаар ихээхэн туршлага хуримтлуулжээ¹.

Америкийн Нэгдсэн Улс. Гэрч, хохирогчийг хамгаалах асуудал анх 1970-аад оны үеэс мафи буюу гэмт бүлэглэлийг устгах хөтөлбөрийн хүрээнд хөндөгдөж эхэлсэн. Тухайн цаг үеийг хүртэл "ometra" буюу мафийн гишүүдийн дунд "чимээгүй байх" гэсэн бичигдээгүй хууль ноёрхож байсан бөгөөд цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан гэмт бүлэглэлийн хууль бус үйлдлийн талаар мэдээлэл өгөх гэсэн хэнийг ч үхлээр заналхийлдэг байв.

Энэ байдлаас гэрч гэмт хэргийн талаар мэдүүлэг өгөхөөс татгалзах, хэргийг мөрдөн шалгах, бодит үнэнийг тогтооход ихээхэн хүндрэл бэрхшээл гарах болсон байна. Иймд тус улсын Конгресс зохион байгуулалттай гэмт хэргийн гэрчийг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх эрхийг Хууль зүйн яаманд олгож "Зохион байгуулалттай гэмт хэрэгт тавих хяналтын тухай" хууль батлагдаж^{1 2} гэрч хамгаалалтын тогтолцоо бий болсон байна.

Улмаар 1982 онд Конгресс "Тэрч хохирогчийг хамгаалах акт³", 1984 онд "Тэрчийн аюулгүй байдлыг сайжруулах акт^{4 5}"-ыг батлан гаргасан бөгөөд одоо тус улсад гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааг Холбооны Маршалуудын алба хэрэгжүүлж байна.

Тус улсад гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөр хэрэгжсэн 30 гаруй жилийн хугацаанд 7000 гаруй гэрч, хохирогч, тэдний гэр бүлийн 9000 гаруй гишүүд Засгийн газартай хэлцэл хийж Маршалын албаар хамгаалуулан төрийн хамгаалалтад орсон байна.

Бусад улс орнууд АНУ-ын Конгрессээс баталсан хууль, засгийн газраас хэрэгжүүлсэн гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрүүдээс чиг баримжаа авч өөрийн орны онцлогт тохируулан эрх зүйн актууд батлан гаргах, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн байгаа нь энэ чиглэлээр тус улсын туршлага бусад улс, оронд туршлага төдийгүй загвар болсон гэж дүгнэж болох байна¹.

Гэрчийг хамгаалалтад авахын өмнө гэрчтэй хэлцэл хийхээр хамгаалалтад авах гэж буй эрх бүхий субъектээс гэрчид "харилцан ойлголцох тухай санамж

¹ Олон улсын түвшинд хохирогчид дэмжлэг (victim support), гэрчид хамгаалал (witness protection) гэсэн үндсэн зарчим үйлчилдэг байна.

² Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. - УБ., 2005. 490 дэх тал.

³ The victim and witness protection act.

⁴ Witness security reform act.

⁵ Өнөөдөр АНУ-ын муж улс бүрт гэрч, хохирогчийг хамгаалах талаар хууль, тогтоомж батлан хэрэгжүүлж байна. Эх сурвалж: Г.Баттулга. Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо ба олон улсын чиг хандлага. илтгэл.

бичиг ¹ ” илгээх бөгөөд түүнд хамгаалах арга хэмжээ, түүнийг хэрэглэх нөхцөлийг тусгасан байна^{1 2}.

Мөн АНУ-ын хорих байгууллагууд гэмт хэргийн хохирогчтой идэвхитэй хамтран, тэднийг дэмжин ажилладаг бөгөөд ялтныг хугацаанаас өмнө суллах асуудлыг шийдвэрлэхдээ тухайн хэргийн хохирогчийн саналыг Тусгай комисс буюу Пароул комиссор³ -оор дамжуулан нууцаар авах ба хохирогч ялтныг сулласан нөхцөл, хугацааны тухай мэдээллийг бичгээр авдаг нь хохирогчийг шаардлагатай мэдээллээр тасралтгүй хангаж байгаагийн тод жишээ юм.

Үүнээс дүгнэхэд АНУ гэмт хэргийг гэрчилсэнээр аюулгүй байдал нь бүрэн хэмжээнд хангагдана гэдгийг гэрч, хохирогчид итгэл төрүүлсэн, энэ нь хуулиар баталгаажсан нь харагдаж байна.

Харин манай орны хувьд гэрч, хохирогчийг хамгаалах хууль эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт жигдрээгүй, хуулийн ач холбогдол мөн чанарыг иргэд, олон нийтэд тайлбарлан таниулах сурталчилах ажиллагаа сул, гэрч, хохирогч гэмт хэргийг илрүүлэхэд ач холбогдол өгдөггүй, аюулгүй байдлаа хамгаалуулах цаашид баталгаатай амьдрах нөхцөлийг хараахан хангаж чадаагүй байна.

Оросын Холбооны Улс. Тус улс эрүүгийн шүүн таслан ажиллагааны гэрч, хохирогчийг хамгаалах асуудалд нэлээд анхаарал хандуулж, энэ талаар бие даасан хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэхийн зэрэгцээ, түүний хэрэгжилтийн талаар Холбооны улсын хэмжээнд удирдлага, зохион байгуулалтын нэлээд арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа улс орны тоонд зүй ёсоор орж байна.

2004 оны 08 дугаар сарын 20-ны өдөр ОХУ-ын Төрийн Думаас “Гэрч, хохирогч болон шүүх таслах ажиллагааны бусад оролцогчдын төрийн хамгаалалтын тухай хууль⁴”-ийг батласан нь гэрч, хохирогч, болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бусад оролцогчдыг төрийн хамгаалалтад эрх зүйн зохицуулалтын үндэс болсон байна.

Хуулийн 2 дугаар зүйлд төрийн хамгаалалтад авах этгээдийг заахдаа гэрч, хохирогчоос гадна эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны дараах оролцогчийг тусгаж өгсөн байна. Үүнд:

- хувийн мөрдөгч;

¹ Memorandum of understanding.

² Жишээ нь гэрч гэм буруутай этгээдийг илчлэх, гэмт хэргийг илрүүлэхэд чухал ач холбогдол бүхий мэдээлэл өгвөл аюулгүй байдлын хамгаалалтын ямар арга хэмжээ хэрэглэх талаар тодорхой заана. Мөн хамгаалуулах гэж буй этгээд санамж бичиг заасан нөхцөлийг биелүүлээгүй тохиолдолд хамгаалалтын арга хэмжээг өөрчлөх талаар тусгана.

³ Parole commission board.

⁴ Гэрч, хохирогч болон шүүх таслах ажиллагааны бусад оролцогчдын төрийн хамгаалалтын тухай Холбооны хууль. Цахим эх сурвалж: <http://7legalacts.ru/doc/federalnvi-zakon-ot-20082004-n-119-fz-o/>

- сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болон тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, ял шийтгүүлсэн болон цагаатсан этгээд, түүнчлэн эрүүгийн хэрэг болон мөрдөн шалгах ажиллагаа нь түдгэлзүүлсэн байгаа этгээд;

- шинжээч, мэргэжилтэн, орчуулагч, хөндлөнгийн гэрч, түүнчлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож буй сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч;

- иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч;

-хууль ёсны төлөөлөгч мөн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хувийн мөрдөгчийн хууль ёсны төлөөлөгчийг шаардлагатай тохиолдолд төрийн хамгаалалтад авахаар тусгасан нь хуулийн үйлчлэх хүрээ хязгаарыг өргөн хүрээтэй авч үзсэн нь онцлог бүхий эрх зүйн зохицуулалт болсон байна.

Түүнчлэн хуулийн 3 дугаар зүйлд зааснаар төрийн хамгаалалтыг дараах байгууллага хэрэгжүүлнэ. Үүнд:

Төрийн хамгаалалтыг хэрэгжүүлэх шийдвэр гаргах эрх бүхий байгууллага: шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын дарга, мөрдөх байгууллагын удирдлагын зөвшөөрснөөр мөрдөгч гаргана.

Аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага: Дотоод хэргийн яам, Холбооны аюулгүй байдлын алба, Гаалийн байгууллага, Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бэлдмэлийн хууль бус эргэлтэд хяналт тавих байгууллага;

Хамгаалалтад авах этгээд цэргийн алба хаагч бол аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохих цэргийн командлагч, ОХУ-ын Зэвсэгт хүчний цэргийн цагдаа хамгаалалтад авна;

Мөрдөн шалгах тусгай газар эсвэл ял эдлүүлэх газар байгаа хамгаалуулагч этгээдийн аюулгүй байдлыг Хууль зүйн яамны Эрүүгийн ял эдлүүлэх системийн бүтцэд байгаа холбогдох байгууллага авна.

Нийгмийн хамгаалалын арга хэмжээг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага: Оросын Холбооны Улсын Засгийн газраас эрх олгосон байгууллага хэрэгжүүлнэ.

Дээрхээс дүгнэхэд ОХУ-д хамгаалалтад байгаа этгээдийн ажлын байр эсвэл сургуулийг өөрчлөх арга хэмжээг хэрэгжүүлэхээр хуульд тусгасан нь давуу талтай бол манай улсын тухайд тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээг тусган хэрэгжүүлж байгаагаараа онцлог байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс. Гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөр тус улсад 1980 оны эхэн үеэс эхэлсэн гэж үздэг. Тухайлбал энэ үед зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор Гамбург хотын цагдаагийн газраас гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд хамтарч ажилласан, хэргийн талаар үнэтэй мэдээлэл өгсөн гэрчийг хамгаалах анхны арга

хэмжээг авчээ. Энэхүү хөтөлбөрийг чиг баримжаа болгон Холбооны эрүүгийн цагдаагийн албанаас гэрч хамгаалах ажиллагааг бүх улс орон даяар системтэйгээр хэрэгжүүлж эхэлсэн байна. Харин гэрч, хохирогчийг хамгаалах тухай бие даасан хуулийг 1998 онд батлан гаргасан бөгөөд энэхүү хууль гарснаар Герман Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэргийн гэрчийг байцаахтай холбоотой шинэ эрх зүйн зохицуулалтыг бий болгосон¹.

Түүнчлэн гэрчийг хамгаалах тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх Эрүүгийн цагдаагийн тусгай хэсгийг анх байгуулж, гэрч хамгаалах газартай хамтран ажиллах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх заавар боловсруулан хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн байна.

Эрх зүйн баримт бичиг хийсэн судалгаанаас дүгнэхэд тус улсад гэрч хамгаалах заавар нь 2001 онд Эрсдэлд буй гэрчийг хамгаалах тухай хууль²-ийг батлан гаргах хүртэл гэрчийг хамгаалах хөтөлбөрийн гол үндсэн баримт бичиг болон хэрэгжиж байжээ. Эрсдэлд буй гэрчийг хамгаалах хууль батлагдсантай холбоотой тус улсад гэрчийг хамгаалах хөтөлбөр эрчимтэй хэрэгжиж холбооны түвшинд болон муж улс бүрт гэрч хамгаалах газрыг байгуулсан байна.

Түүнчлэн холбооны эрүүгийн цагдаагийн газраас улс орны хэмжээнд мөрдөн шалгаж буй бүх хэргийн гэрчийг хамгаалах төдийгүй муж улсуудад, түүнчлэн олон улсын хэмжээнд гэрч хамгаалах ажлыг удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж эхэлжээ.

Бүгд Найрамдах Итали Улс. Тус улсын хувьд эрт үеэс зохион байгуулалттай гэмт бүлэглэл буюу "мафи"-гаар дэлхийд алдартай төдийгүй түүнтэй хийх тэмцлийг амжилттай хэрэгжүүлэх нь үе үеийн засгийн газрын өмнө томоохон сорил, асуудал байсаар ирсэн. Тийм ч учраас гэрч, хохирогчийг хамгаалах Итали Улсын хөтөлбөрийг судлаачид дэлхийн хамгийн эртний хөтөлбөрийн нэг гэж үздэг.

Итали Улсад гэрчийг хамгаалах асуудал нь терроризм болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй хийх тэмцлийг эрчимжүүлэх арга хэмжээний хүрээнд бий болсон. Гэрчийг хамгаалах хөтөлбөр 1984 онд албан ёсоор хэрэгжих эхлэл тавигдсан бөгөөд энэ нь тухайн үеийн гэмт бүлэглэлийн гишүүн

¹ Онц аюултай гэмт хэрэг, ялангуяа улс төрийн зорилготой алах хядах, хомроглон устгах шинжтэй болон бусад зохион байгуулалттай гэм хэргийг илрүүлэхэд чухал ач холбогдол бүхий гэрчийн мэдүүлэг өгөхөд бэлэн байгаа нь түүнд болон тэдний гэр бүл, үр хүүхэд, садан төрөл, ойр дотны хүмүүсийн эрүүл мэнд, сайн сайхан байдал, эрүүл мэнд, эд хөрөнгөд нь аюул учруулж болохуйц нөхцөл байдал байгаа бол зохих ёсоор гэрчийг хамгаалалтад авах тухай хуульд заасан.

² Тус улсад ихэнх тохиолдолд гэмт хэргийн улмаас сэтгэл зүйн хүнд дарамт, стресст орсон хохирогч, гэрчийг хамгаалалтад хамруулдаг. Иргэний баримт бичиг, үнэмлэхэд үндэслэн шинэ намтар түүхтэй хүн бий болгох, цаашид түүнийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгосон.

байсан этгээд-ийг томоохон бүлэглэлийн эсрэг мэдүүлэг өгөхөд ашиглан үүний үр дүнд гэмт бүлэглэлийн толгойлогч, гишүүд нийт 350 орчим хүнийг илчлэн баривчилж байжээ.

1988 онд баталсан “Мафиас үйлдэж байгаа гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг зохицуулах талаар авч хэрэгжүүлэх хойшлуулашгүй арга хэмжээний тухай” №726 хуулиар мафийн бүлэглэлийн эсрэг хамтран ажилласан буюу тэдний үйл ажиллагаатай холбоотой баримт, сэлтийн тухай мэдүүлэг өгснийхөө төлөө ноцтой аюулд учирч байгаа этгээдийг хамгаалалтад авч, шаардлагатай бүх арга хэмжээг хэрэглэж байх зөвшөөрлийг гэмт бүлэглэлтэй тэмцэх комиссараас зохих эрх бүхий байгууллагад өгч байхыг зөвшөөрсөн байна*². Гэмт бүлэглэлтэй тэмцэх энэхүү удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний үр дүнд 1990 оны эцэст мафийн 1000 гаруй гишүүд болон зохион байгуулалттай гэмт хэргийг илрүүлсэн томоохон амжилтад хүрсэн байна. Гэсэн хэдий ч Итали Улсын гэрч хамгаалах хөтөлбөр нь үүсэл, сонгосон арга барил болон гэрчийг хамгаалах хөтөлбөрийн хэрэгжилт, түүний удирдлага, зохион байгуулалтад төгс бус, алдаатай байсан зэргээс шалтгаалан багагүй шүүмжлэлд өртсөн. Тухайлбал, гэрчийн гэр бүлийн гишүүд халдлагад өртөх, зарим гэрч худал мэдлээлэл өгч бусдыг гүтгэх сөрөг үзэгдэл гарах болсон байна.

1991 онд Итали Улсад “Хуулийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа этгээд, тэдний гэр бүлийн гишүүдийг хамгаалах тухай хууль №82”-ыг батлан гэрчийг хамгаалах шинэ эрх зүйн орчинг бий болгожээ. Хуулийн 9 дүгээр зүйлд “хэрэв мафитай тэмцэх ерөнхий комиссарын зөвшөөрсөн арга хэмжээ хангалттай бус гэж үзвэл, тусламжийн нэмэлт арга хэмжээг багтаасан хамгаалалтын тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх” тухай заасан. Улмаар 2001 онд хуулийг шинэчлэн зарчмын томоохон өөрчлөлтийг бий болгосон байна. Тухайлбал, гэрчийг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын хүрээнд бие даасан бүтцийг бий болгон энэ чиглэлээр мафи, мансууруулах бодистой холбоотой болон хүн амины гэмт хэргийн гэрч, мэдээлэгч, хуульд 5-20 хүртэл жилийн хорих ялаар шийтгүүлэхээр заасан гэмт хэргийн гэрч, аюулд өртөж болзошгүй гэрч, мэдээлэгчийн ойр дотны хүмүүсийг хамгаалалтад авахаар тусгасан байна.

Хуульд зааснаар хамгаалалтын арга хэмжээ дараах төрөлтэй байна. Үүнд:

Гэмт бүлэглэлийн гишүүн байсан Томмазо Бушеттаг мэдүүлэг өгсөний дараа хамгаалалтад авч улмаар бичиг баримт болон гадаад төрхийг өөрчлөх хамгаалалтын арга хэмжээг авч улмаар шинэ нэрээр АНУ руу гарчээ. Цахим эх сурвалж, холбоос: <http://www.italvmatla.ru/italiya/koza-nostra/prochie/tommazo-bushetta/>

² Ч.Няжүрэн. Гэмт хэргийн виктимологи. - УБ, 2005. 511 дэх тал.

- Түр зуурын төлөвлөгөө'-ний дагуу амьдрах зардлыг тооцон 180 хоног өөр газар нүүлгэн шилжүүлэх;

- Нүүлгэн шилжүүлж буй хүмүүст зориулсан хамгаалах, нийгэмшүүлэх төлөвлөгөөний “тусгай арга хэмжээ”-г хэрэгжүүлэх;

- Нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой түр үнэмлэх бичиг баримт олгох, санхүүгийн болон хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх;

- Хорих ял эдэлж буй мэдээлэгч, гэрчийг хамгаалалтад авахад эдлэх ялын 'Д-ээс доошгүй хувийг эдэлсэн байх, эсвэл 10 буюу түүнээс дээш. бүх насаараа хорих ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн хэргээ өөрөө хүлээсэн байх шаардлагатай гэж заажээ.

Түүнчлэн төв комисс хамгаалалтад авах талаар шийдвэр гаргахдаа дараах этгээдийн зөвшөөрлийг үндэслэнэ. Үүнд:

1. Дотоод яамны Төрийн нарийн бичгийн даргын орлогчийн;
2. Прокурор болон хоёр шүүгчийн;
3. Зохион байгуулалттай гэмт хэргийн чиглэлээр ажилладаг таван мэргэжилтний тодорхойлолт;
- 4, Бичиг баримт өөрчлөх хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн бичиг баримтыг Төв комисс баталгаажуулна гэсэн эрх зүйн зохицуулалтыг шинэ хуульд тусгаж өгсөн нь дэвшилттэй болсон байна.

Австрали Улс. 1983 оноос эхлэн тус улсад Хааны комиссоос зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлсэн бөгөөд гэмт бүлэглэлийн зохион байгуулагчид, удирдагчийн талаар мэдээлэл өгсөн, гэмт бүлэглэлийн гар хөл бологсод буюу доогуур түвшний оролцогч гишүүдэд боломж олгох талаар хөндсөн байна. Энэхүү арга хэмжээ хэрэгжиж эхэлсэн үеэсээ тодорхой үр дүнд хүрсэн бөгөөд зохион байгуулалттай гэмт хэргийг илчлэхэд тусалсан, мэдүүлэг өгсөн, хамтарж ажилласан хүнийг цагдаагийн байгууллага 24 цагийн турш хамгаалалтад авч, бичиг баримтыг солих, нүүлгэн шилжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн байна.

1988 онд Парламентын хамтарсан хороо гэмт хэргийн илрүүлэлтийн нөхцөл байдалд хийсэн судалгаан дээр үндэслэн гэрч хамгаалалын асуудлын талаар хэлэлцэн дараах хоёр чухал шийдвэрийг гаргахад хүрчээ. Үүнд:

1. Гэрч хамгаалах тухай 1994 оны хуулийг батлан гаргаж гэрч хамгаалалын тогтолцоог Хамтын нөхөрлөлийн орнуудын түвшинд хүргэх;
2. Австралийн үндсэн бүс нутаг болон хэд хэдэн мужид гэрчийг хамгаалах дагавар хууль батлах шийдвэр гарсан байна.

Түүнчлэн хууль батлагдан гарснаар үндэсний хэмжээний гэрч хамгаалах хөтөлбөр хэрэгжиж, гэмт хэргийн гэрч хамгаалалтад авагдсанаар хэргийн

¹ Temporary plan.

шийдвэрлэлтэд ахиц гарсан төдийгүй 1997, 2002 онд тус нэмэлт өөрчлөлт оржээ.

Бүгд Найрамдах Турк Улс. Тус улсад 2004 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58 дугаар зүйлд гэрчийг хамгаалах талаар анх удаа зохицуулсан байна. Харин Парламентаас 2007 оны 12 дугаар сарын 27-ны өдөр "Тэрчийг хамгаалах тухай хууль"-ийг батлан гаргасан бөгөөд хуулийн зорилго "эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд гэрчийн үүрэг гүйцэтгэж байгаатай холбоотойгоор өөрсдөд нь, эсхүл хуульд заасан ойр дотны хүмүүсийн амь нас, эрүүл мэнд, бие махбодийн бүрэн бүтэн байдал, эсхүл эд хөрөнгөд нь ноцтой ба бодит аюул тулгарах болон хамгаалалт шаардлагатай этгээдийг хамгаалах зорилгоор авах арга хэмжээтэй холбогдох эрх зүйн үндэслэж зохицуулахад оршино" гэж тодорхойлсон байна. Ийнхүү гэрчийг хамгаалах бие даасан хуулийг батлан гаргасан боловч хохирогчийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах талаар хангалттай эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Гэрчийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлд гэрчийг хамгаалах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

1. Биеийн байцаалт болон оршин суугаа хаягын мэдээллийг бүрэн нууцлах болон өөрсдөд нь хүргүүлэх мэдэгдэлтэй холбоотой өөр хаягт байршуулах;

2. Шүүх хуралд байлцах эрх бүхий этгээдийг байлцуулахгүйгээр мэдүүлэг өгөх, эсхүл дуу буюу дүрсийг нь өөрчлөн тусгай нөхцөлд мэдүүлэг авах;

3. Бие махбодын хамгаалалт;

4. Биеийн байцаалт болон холбогдох бусад мэдээлэл, баримт бичгийг өөрчлөх ба зохицуулах;

5. Хэргийн бүртгэл, цэргийн татвар, иргэний болон нийгсийн хамгаалал болон бусад төстэй мэдээлэл ба бүртгэлийг өөрчлөх ба зохицуулах;

6. Иргэний болон жолооны үнэмлэх, гэрлэлтийн баталгаа, диплом, ба бүх төрлийн зөвшөөрөл зэрэг албаны баримт бичгийг өөрчлөх ба зохицуулах;

7. Хөдлөх ба үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой эрхийг ашиглахад чиглэсэн ажиллагааг хийх;

8. Түр хугацаагаар амьдрахад нь зориулж эд хөрөнгийн тусламж үзүүлэх;

9. Ажиллаж байгаа этгээдийн ажлын байр эсхүл суралцаж байгаа этгээдийн суралцах бүх төрлийн боловсролын байгууллагыг өөрчлөх;

10. Улс дотроо өөр газар амьдрах нөхцөлийг хангах;

11. Олон улсын гэрээ болон харилцан адил байх зарчмын хүрээнд түр хугацаагаар өөр улсад байрлуулах боломж бий болгох;

12. Физиологийн дүр төрхийг өөрчлөх пластик мэс заслын аргаар эсхүл мэс засалгүйгээр өөрчлөх ба үүнтэй нийцсэн биеийн байцаалтын мэдээллийг зохицуулах зэрэг хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар эрх зүйн зохицуулалтыг бий болгосон байна.

Гэрчийг хамгаалах арга хэмжээнд хамаарагдах этгээдийг Гэрчийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд дараах байдлаар тодорхойлж тусгажээ. Үүнд:

1. Эрүүгийн шүүх таслах ажиллагаанд гэрчийн мэдүүлэг өгч байгаа этгээд;
2. Эрүүгийн шүүх таслан ажиллагаанд мэдүүлэг өгч байгаа гэмт хэргийн хохирогч;
3. Дээрхи гэрч, хохирогчийн сүйт бүсгүй, сүйт залуу, гэр бүл салсан эхнэр, нөхөр, цусан болон ургийн холбооны дээд, доод хоёр дахь үеийн хамаатан садан болон өргөмөл хүүхэд, тэдэнтэй холбоотой болон дотно харилцаатай хүмүүс хамгаалалтад хамрагдана.

Бүгд Найрамдах Солонгос Улс. Тус улсад 1980 онд анх хохирогчийн эрхийг хамгаалах тухай хууль, 2005 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 7731 дүгээр тогтоолоор “Тэмт хэргийн хохирогчийг хамгаалах хууль” болон батлагдан хуулийг хэрэгжүүлэх, түүний удирдлага, зохион байгуулалтыг улс орон даяар хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний хүрээнд 2006 оны 12 дугаар сард “Хохирогчийг хамгаалах үндсэн төлөвлөгөө”-г боловсруулж, түүндээ дараах бодлогыг тусгасан байна. Үүнд:

Хохирогчид хохиролын мөнгөн төлбөр олгож байх;

- Мөрдөн шалгах ажиллагаанд оролцох журам;

Хохирогчийн хувийн амьдралын тайван байдал, амь насыг хамгаалах;

Сургалт хүмүүжлийн судалгаа болон хуулийн сурталчилгаа, иргэд, байгууллагын тусламж авах, санхүү хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, удирдах.

БНСУ-д одоо гэрч, хохирогчийг аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой дараах хууль мөрдөгдөж байна. Үүнд:

- Хүнд гэмт хэргийн мэдээлэгчийг хамгаалах тухай хууль;

Онц хүнд гэмт хэргийн ял шийтгэлийн тухай тусгай хууль;

Бэлгийн хүчирхийлэлийн ял шийтгэх болон хохирогчийг хамгаалах тухай хууль;

Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах хууль зэрэг хууль эрх зүйн акт үйлчилж байна.

Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах хуулийн 2 дугаар зүйлд гэмт хэргийн хохирогч дараах эрхийг эдлэнэ гэж тусгасан байна. Үүнд.

зөрчигдсөн эрхээ хамгаалуулах, сэргээх;
нэр төр болон аюулгүй байдлаа хамгаалуулах;
байцаан шийтгэх бүхий л ажиллагаанд оролцох гэж тусгажээ.

Харин хуулийн 4 дүгээр бүлэгт зааснаар гэмт хэргийн хохирогчийг хамгаалахад төр дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, туслах тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх;

Гэмт хэргийн хохирогчийн хамгаалах, туслахад зориулагдсан бодит байдлын судалгаа, шинжилгээ, сургалт, сурталчилгаа явуулах;

Гэмт хэргийн хохирогчийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжид нхэмэлт өөрчлөлт оруулах, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авах, зохих хөрөнгийг гаргах үүрэгтэй байхаар тусгасан байна.

Түүнчлэн хохирогчийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх талаар үе шаттай, уялдаа холбоотой бодлого хэрэгжүүлэхийн тулд Хууль зүйн сайд 5 жилийн төлөвлөгөө гарган гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийг хамгаалах холбоогоор хэлэлцүүлэх ба холбогдох засаг захиргааны байгууллага болон хот, аймгийн удирдлага төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааны он дараалсан үе шаттай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг байна .

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс. Тус улсад гэрч хамгаалах үйл ажиллагаа 1996 оны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний стратегийг батлагдах хүртэл 1977 оны Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагдаж байжээ. Хуулийн зохицуулалтыг авч үзвэл гэрч хамгаалахтай холбоотой заалтууд ерөнхийдөө албадлагын шинж чанартай байсан бөгөөд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах дэглэмийн үед гэрчээс мэдүүлэг, нотлох баримт гаргаж өгөхөд албадлага хэрэглэж байв.

1996 оны Өмнөд Африкийн парламентэд тус улсын засгийн газрын тавьсан тайланд аюул занал, халдлагад өртөж болзошгүй гэрчүүдээс мэдүүлэг авах, тэдний гаргасан нотлох баримтыг хамгаалах, гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд гэрчийг хамгаалах ажиллагаа хангалтгүй байгааг хууль тогтоогчид хүлээн зөвшөөрсөн байна. Иймд тус улсын парламентаас Гэрч хамгаалах тухай хуулийг 2000 онд эцэслэн баталсанаар өмнөх тогтолцоог бүр мөсөн өөрчилж гэрч, хохирогчийг хамгаалах шинэ тогтолцоог бий болгож

¹ Хохирогчийн эрхийн судалгааны пюв. Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал. судалгааны ажлын тайлан. - УБ., 2010. 88-89 дэх тал.

амжилтад хүрч чадсан төдийгүй үүний үр дүнд гэрч, хохирогч хамгаалах олон хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсээр иржээ .

Дээрхи улс орнуудын гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааны эрх зүйн зохицуулалт болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын орчинд дүгнэлт хийж үзвэл улс орон бүр гэмт хэрэгтэй тэмцэхэд дэвшил гаргахад чиглэсэн тусгайлсан бодлого хэрэгжүүлэх, шинэ шатанд гаргах шаардлагын үүднээс гэрч, хохирогчийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах ажиллагааг төрийн бодлогын түвшинд тавьж, улмаар тодорхой амжилтад хүрсэн нь харагдаж байна. Түүнчлэн зөвхөн хууль батлаад зогсохгүй энэ чиглэлээр тусгай хөтөлбөрүүдийг боловсруулан улсынхаа хэмжээнд хэрэгжүүлж, үйл ажиллагааны бие даасан нэгжийг байгуулан гэрч, хохирогчийн аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх төсөв, санхүү, техник хангамжийн асуудлыг цогц байдлаар шийдвэрлэж байгаа манайд улсад нэвтрүүлж болох дэвшилттэй туршлага гэж дүгнэж байна.

Судалгааны ажлын энэхүү дэд бүлэгт гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлэн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг амжилттай хэрэгжүүлж байгаа хөгжингүй улс орны туршлагыг судлах зорилт дэвшүүлэн дараах дүгнэлтэд хүрлээ.

1. НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай” тунхаглалыг батлан гаргаснаар олон улсын хэмжээнд хохирогчийн эрхийн талаар гаргасан үндсэн баримт бичиг болжээ. Энэхүү тунхаглалын 6 дугаар зүйлд “гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах”-ыг улс орон бүрт уриалсан нь гэрч, хохирогчийг хамгаалах олон улсын эрх зүйн эх сурвалж болсон байна.

2. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгох гол ач холбогдол нь төрийн хамгаалал, хяналт. үйлчилгээний гадна үлддэг байсан гэрч, хохирогчийг хамгаалан, тэдэнд төрийн хамгаалалтын найдвартай байдлыг ойлгуулан таниулж, улмаар хэргийн үнэн зөвийг тогтоох үйл явцад өөртөө итгэл үнэмшилтэй оролцох боломжийг бүрдүүлж өгч байгаад мөн чанар нь оршиж байна.

Үүний тулд холбогдох хуулийг олон нийтэд сурталчилан таниулах ажлыг хүртээмжтэй, оновчтой хэлбэрээр тасралтгүй зохион байгуулах, шүүх эрх мэдэл, хууль сахиулах болон төрийн, төрийн бус байгууллага, иргэд, олон

¹ Хууль зуйням, Нээлттэй нийгэм форум. “Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” сэдэвт хэлэлцүүлгийн илтгэлийн эмхэтгэл. - УБ. 2016. 10 дахь тал.